

ХЯТАД, МОНГОЛЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНД ӨВӨР МОНГОЛЫН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

*Лю Хунруй**

1989 оноос Хятад, Монгол хоёр улсын харилцаа тогтворжиж, сайн хөршийн найрсаг харилцаа улам гүнзгийрэн, дээд төвшинд удаа дараа харилцан айлчлал хийснээр эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа хүрээгээ тэлж, Хятад, Монголын харилцааны шинэ үе эхэлсэн гэдгийг онцлон тэмдэглэж байна. БНХАУ-ын дарга Ху Жиньтао 2003 оны 6 дугаар сарын 4-5-ны хооронд Монгол Улсад анх удаа ажлын айлчлал хийх үеэр, Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди хоёр улсын харилцаа гүнзгийрч байгааг бүхэлд нь үнэлж: “Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэлцсэн нөхөрсөг харилцааг байгуулан хөгжүүлж байна” гэж хэлснээс үзэхэд хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа харилцааны нэг шинэ төвшинд гарчээ.

БНХАУ-ын дарга Ху Жиньтао Монгол Улсын төрийн тэргүүнтэй ярилцахдаа Хятад, Монголын харилцааны хөгжилд Өвөр Монголын гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдлыг бүрэн дүүрэн тодорхойлж: “манай улсын ӨМӨЗО нь Хятад, Монгол хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд гүүрийн үүрэг гүйцэтгэхийг бид дэмжинэ” гэв. 2004 оны 10 дугаар сарын 9-12-ны өдрүүдэд ӨМӨЗО-ы дарга Янь Жин тэргүүтэй өөртөө засах орны засгийн газрын төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улсын ерөнхийлөгч мөн л Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Өвөр Монгол гүүрийн үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлээд, Хятад улс болон түүний бусад муж, хот, өөртөө засах орны үйлдвэр, аж ахуйн газруудаас Монгол Улсын хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтын талаар танилцуулсан юм. Энэхүү танилцуулгаас үзэхэд хоёр улсын тэргүүн нар ӨМӨЗО, Монгол Улсын хооронд эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг алхам алхамаар хөгжүүлэх нөхцөл бүрдэж байгаа, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хүрээнд хоёр талын гүүр болно гэдгийг хүлээн зөвшөөрч байв.

Улс төрийн харилцаа тасралтгүй үргэлжилж, хоёр улсын хоорондын эдийн засаг, худалдааны харилцаа мөн түргэн хөгжиж байна. Ялангуяа ӨМӨЗО нь Хятад, Монголын эдийн засгийн найрсаг харилцааг хөгжүүлэхэд ихээхэн идэвхтэй үүрэг гүйцэтгэж байна. Өвөр Монголын эдийн засаг, худалдааны танхимын нэгтгэсэн тооцоогоор Монгол Улсад Хятадаас оруулж буй импортын барааны үнийн дүнгээр Өвөр Монгол ойролцоогоор 70%-ийг эзэлж байна. Ийнхүү ӨМӨЗО нь

*Лю Хунруй - ӨМӨЗО-ы Зүүн хойт Азийн судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж буйг үндэслэн дараах гурван давуу талыг чухалчлан авч үзье.

**Нэг. Өөртөө засах орны газар зүйн байрлал
болон соёл иргэншлийн давуу тал**

Өвөр Монгол нь Хятад улсынхаа дотор “3 хойд бүс”-ийн заагт оршдог бөгөөд 8 мужтай залгаж, Хятадын зүүн хэсгээр Бээжин, Тяньжин, Таншань зэрэг зүүн гурван мужийн хотуудтай ойр, далайн тойргийн эдийн засгийн хүрээнд багтдаг; баруугаараа “алтан гурвалжин” бүсийн Баолан төмөр замаас хамааран, улсын баруун бүсийн хөгжлийг эрчимжүүлэх төсөлд чухал бүс нутаг болж, Сылун, Хайлан зэрэг эдийн засгийн шинэ бүсэд багтаж байна; хойгуураа Орос болон Монгол Улстай хиллэх агаад Монгол Улстай нийтдээ 4600 гаруй км газраар хиллэдэг. ӨМӨЗО-ы хилийн дотор Хятад, Монголын хилийн 8 боомт, улирлын чанартай түр ажиллагаатай боомт 4 байдаг нь Хятад, Монголын хоорондын импорт, экспортын барааны гол чухал төв болохын сацуу Өвөр Монгол, Монгол Улсын хооронд үйл ажиллагаа явуулдаг. Дээр нь нэмэж хэлэхэд, Хятад улсын дотоодын эдийн засгийн бодлого ӨМӨЗО-ы тухайд, Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа бүрэн дүүрэн өргөжин хөгжихөд өөртөө засах орны газар зүйн байршлын давуу тал баталгаатай үүрэг гүйцэтгэнэ. Иймээс Өвөр Монголыг зөвхөн Хятадын эдийн засгийг хөгжүүлэх болон гадаадад нээлттэй байх бодлогын ерөнхий бүтцэд зүүн, баруун бүсийг нээх чухал байршилтайд тооцдог төдийгүй мөн Хятадын хойд бүсийг нээлттэй болгох хамгийн алслагдсан нутаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Нөгөөтэйгүүр Өвөр Монголын газар нутаг болон Монгол Улс нь эртний түүхэн уламжлалтай, хоёр талын хэл, соёл, сэтгэхүй, ёс заншил, буюу үйлдвэрлэлийн арга ажиллагаа болон амьдралын хэв загвар адил төстэй, бие биеэ ойлгоход хялбар дөхөм учраас хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд энэхүү соёл иргэншлийн давуу тал ховор боломж тохиож байна.

Хоёр. Нөөц баялаг, бодлогын давуу тал

“Зүүнтэйгүүр ой мод, баруугаар төмөр, урдуураа үр тариа, хойгуураа мал сүрэг, газар сайгүй нүүрс” гэж Өвөр Монголын нөөц баялгийн давуу талыг дүрслэн бичдэг. 50 гаруй жилийн бүтээн байгуулалтын хөгжилд Өвөр Монгол нь Хятад улсын газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болон эрчим хүчний түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн чухал бааз суурь болж ирэв. Өвөр Монгол 1,3 тэрбум га тал нутагтай, нийт улсын хэмжээнд томоохонд тооцогддог таван тал нутгийн эхэнд ордог; 100 мян.га тариалангийн газартай, нэг хүнд ногдох тариалангийн талбай нь улсын нийт дундаж төвшнөөс 4 дахин их; 280

сая га ой модоороо улсын хэмжээнд хоёрдугаарт ордог. Ноос ноолуур, арьс шир, хонь, үхрийн мах, сүү зэрэг мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээгээр улсдаа тэргүүлж, нэг хүнд ногдох үр тарианы үйлдвэрлэлийн хэмжээгээр улс даяар гуравдугаар байр эзэлдэг. Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нөөцөөр баялаг, Өвөр Монголын газар тариалан мал аж ахуйг үйлдвэржүүлэх болон газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн боловсруулалтын үйлдвэр эрчимтэй хөгжиж байна. Или, Ордос, Монгол үхэр, Лу ван, Ту чи, Син фа зэрэг нэртэй үйлдвэрүүдийн алдартай бүтээгдэхүүний нэр шошго олноор төрөн гарсаар байна.

Урт хугацааны турш Өвөр Монгол нь үндэстний эв нэгдэл, хилийн аюулгүй байдал, улс төрийн тогтвортой, таатай нөхцөл байдлыг сахин хадгалж ирсэн билээ. Үндсэн хууль хийгээд үндэстний өөртөө засах орны хууль эрхийн дагуу улсаас Өвөр Монголд олон талын хөнгөлөлттэй бодлого явуулан шинэ зуунтайгаа золгов. Улмаар Өвөр Монгол нь улсаас хэрэгжүүлж буй баруун бүсийг нээн хөгжүүлэх стратегийн их төсөлд багтсан 12 муж, ӨЗО-ы нэг болсноор улсаас баруун бүс нутгийг нээлттэй болгон хөгжүүлэхэд холбогдох хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлж байна. Эдгээр нь Өвөр Монголыг нээлттэй болгох бүтээн байгуулалтын их үйлс, эдийн засгийн үсрэнгүй хөгжилд маш их үүрэг гүйцэтгэх болно.

Гурав. Эдийн засгийн хамтын ажиллагааны далд хүчин чадал, харилцан нөхөх чадвар

Өдгөө БНХАУ болон Монгол Улс дипломат харилцаа тогтоогоод 55 жил болж байна. БНХАУ-ын дарга Ху Жиньтаогийн урилгаар Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди 2004 оны 7 дугаар сарын 1-6-ны хооронд БНХАУ-д айлчилав. Айлчлалын хугацаанд хоёр тал Хятад, Монголын хилийн боомт болон түүнийг удирдан явуулах гэрээ; Хятадаас Монголд буцалтгүй тусламжаар нийлүүлэх эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны гэрээ; буцалтгүй тусламжаар хүнсний бараа нийлүүлэх талаар ноот солилцож, Хятадын ардын банк болон Монгол Улсын банкуудын хооронд төлбөрийн тооцоо хийх гэрээнд тус тус гарын үсэг зурсан байна. Хоёр талын тэргүүн нар Хятад, Монгол хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа аажмаар бэхжин амжилтанд хүрч буйг онцлон тэмдэглэв. 7 дугаар сарын 6-нд Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хүрээнд явуулсан нөхөрсөг уулзалт дээр Н.Багабанди ерөнхийлөгч Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хэрэгжилт “хоёр талд харилцан ашигтай байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй” гэв. Тэрбээр мөн 2003 оны 6 дугаар сард БНХАУ-ын дарга Монгол Улсад айлчлах үеэр хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа алхам алхамаар гүнзгийрч байгааг дурьдсан билээ. Хөрөнгө оруулалтыг

маш ихээр нэмэгдүүлж, байгалийн нөөц баялгийг хамтран нээж хөгжүүлэх нь хоёр улсын хамтын ажиллагааны чухал салбар бөгөөд тухайлбал хоёр тал хамтран Монголын төмрийн орд, газрын тос, нүүрсний ордыг нээн хөгжүүлж болох юм. Энэ өдрөөс хойш Хятад руу эдгээр үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ гэдгээ тэр илэрхийлсэн юм.

Нөхөрсөг уулзалт дээр Хятадын талын төлөөлөгчид, Хятадын үйлдвэр аж ахуйн газруудын бодит хүчин чадал, техник технологи, ялангуяа уул уурхайн орд газрыг нээж, үйлдвэрлэлийг хөгжүүлэн их орлого олохын тулд хамтран ажиллах тухай Монголын талын дэвшүүлсэн санал хүсэлтийн дагуу “хоёр талдаа харилцан ашигтай байх” зорилгодоо хүрэх болно гэж мэдэгдэв. Ингээд Хятадын Уул уурхайн нэгдсэн хороо, Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж, хоёр тал уул уурхайн үйлдвэрийг нээн хөгжүүлэх, экспорт, импортын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн юм.

ӨМӨЗО болон Монгол Улсын харилцаанд нэн тэргүүний байр эзэлж буй зарим нэг үйлдвэрийн бүтээгдэхүүний импорт, экспортын талаар авч үзье. Тухайлбал: Монгол Улсын элсэн чихэр, хүнсний ногоо, гурилын зах зээлийн үндсийг Өвөр Монголын үйлдвэр, аж ахуйн газар эзэлж (монопольчилж), Монголын зах зээл дэх хүнсний элсэн чихрийн 90%-ийг нь Бугатын “Цао юань” (“Тал нутаг”) хэмээх үйлдвэр эзэлдэг. Гурил, төмсийг Өвөр Монголын Хэ тао дүүргийн үйлдвэр аж ахуйн газрууд нийлүүлдэг. Зөвхөн Өвөр Монголд Монгол Улсын зэсийн ордын нунтагийн импортоос шалтгаалах хэмжээ маш өндөр, жилийн импортын хэмжээ 400 мян.тн-д хүрч байгаа нь Монгол Улсын дотоодын үйлдвэрлэлийн хэмжээний 90%-ийг эзэлж байна гэсэн үг. Үүнээс гадна Хятад улсын дотоодын эрчим хүчний нийлүүлэлтийн асуудал хурцалснаас коксжсон нүүрсний эрэлт хэрэгцээ маш их дутагдах боллоо. 2004 оны эхнээс л дөнгөж боомт газрыг жилд тогтмол нээх болсноор эхний улиралд импортын барааны нийт хэмжээ өнгөрсөн оныхоос 150%-иар нэмэгдлээ. Хэрэв Хятад, Монголын хилийн боомтыг 5 хоног хаавал ямар үр нөлөө гарах вэ? Тэгвэл Монгол Улсад хүнсний ногоо, гурил нийлүүлэлт магадгүй зогсох байх, үүнээс улбаалан Өвөр Монголын Бугат, Ордосын ган төмөрлөгийн компани, цахилгаан станц бас эрчим хүчний түүхий эдээр дутагдаж маш их алдагдалд орж болох юм.

Хоёр улсын засгийн газрын хамтын хүчин чармайлтаар ойрын жилүүдэд Хятад, Монголын эдийн засагт нааштай өөрчлөлтүүд гарч байна. Өвөр Монгол, Монгол Улсын хоорондын худалдааны нийт дүн өсөн нэмэгдэж, тасралтгүй өргөжиж байгаа хэдий ч хоёр талын импорт,

экспортын худалдаа тасралтгүй өсөн нэмэгдэхэд дэд бүтцийн бүтээн байгуулалтын зогсонги байдал маш том саад учруулж буйг бид харж байна.

Үүнээс гадна дан ганц худалдааны бараа бүтээгдэхүүнээр экспорт, импортыг явуулбал зах зээл дэх худалдааны ерөнхий дүн маш ихээр өөрчлөгдөх болно, иймээс зөвхөн хоёр талын хүчин чармайлтаар дэд бүтцийг сайжруулан бүтээн байгуулахын тулд харилцан хөрөнгө оруулалт хийж байж сая “харилцан ашигтай байх” зорилгодоо хүрэх юм.

2004 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар Өвөр Монголын хилийн доторхи төмөр зам болон засмал замын хөдөлгөөний хүчин чадал нэгэнт бүрэн шийдэгдсэн гэх боловч ялангуяа Эрлянаас Тяньжин хүртэлх хэсгийнх хүндрэлтэй байгаа, 2004 оны эхэн гэхэд мод импортоор гаргахад Эрляны хилийн боомтод олон хоногоор саатан хүлээгдэж улмаар хууль бусаар тээвэрлэн гаргахад хүргэж, Монгол Улсын төмөр замын шугамд засвар хийгдээгүй, ачааны вагоны ерөнхий тоо хэмжээ хангалтгүй зэрэг асуудлыг бүрэн шийдвэрлээгүй гэх мэтийн бэрхшээл нэг жилийн дотор удаа дараа гарсаар байна. Өвөр Монголын Бугатын ган төмөрлөгийн компани өнөөдөр Монгол Улсын хойд зүгт байдаг төмрийн орд газрыг нээн хөгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан билээ. Эхний жилд Бугатын ган төмөрлөгийн үйлдвэрт 3 сая тн төмрийн олдвор эрдэс чулуу нийлүүлэх ёстой боловч Эрляний боомтын бүтэн жилийн тээвэрлэлтийн хэмжээ дөнгөж 5 сая тн байна. Өөрөөр хэлбэл, хэрвээ Эрляний боомтоор Бугатын төмрийг жилд импортлох ёстой хэмжээгээр бүрэн гаргах аваас тус ӨЗО-ы бусад экспорт, импортын бараанд ноцтой нөлөөлөх нь дамжиггүй. ӨМӨЗО-д Бугатын төмөрлөгийн үйлдвэртэй адил дэд бүтцийн бүтээн байгуулалтын нөхцөл байдлыг сайжруулахтай холбогдсон иймэрхүү тулгамдсан чухал чухал асуудал бусад үйлдвэр аж ахуйн газруудад маш их тохиолдож байна. Хятад, Монгол хоёр улсын засгийн газар энэ бүх байдлыг хүлээн зөвшөөрч, дэд бүтцийн бүтээн байгуулалтанд хөрөнгө оруулалтын хүчин чадлыг нэмэгдүүлж, өнөөдөр Хятадын Эрляны хилийн боомтын буудал, талбайг өөрчлөн өргөжүүлж, барилгын инженерийн ажил бүрэн дуусч, Эрлян хотын төмөр замын хилийн боомтоор жилд тээвэрлэх хүчин чадлын дээд хэмжээ нэмэгдэн 1 сая тн-д хүрлээ. Эрлян хотын төмөр замын хилийн боомт нь манай улсын төмөр замын тээврийн 4 том боомтын нэг юм. Урдуураа дайран өнгөрөх төвлөрсөн хоёр шугам болон Бээжин-Бугат, Бээжин-Харбин, Бээжин-Гуанжоу зэрэг төмөр замын хуурай газрын шугамыг холбодог, хойгуураа Эрлянаар дамжин Сибирийн төмөр замаар шууд Москва хүрдэг, “Европ-Эх газрын гүүр” хэмээн нэрлэгдэн Хятадын гадаад худалдаа, эдийн засаг болон эрчим хүчний тээвэрлэлтэнд маш чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсын төмөр зам өргөн (рельс), Хятад улс олон улсын стандартын нарийн зам ашигладаг болохоор хилээс гарах, орохдоо цуваа вагоны дугуйг (рельс) зайлшгүй солих шаардлагатай байдаг.

Хэдийгээр Хятадын эдийн засаг, худалдааны үйл ажиллагаа өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, төмөр замын буудал, дугуй солих тоног төхөөрөмжийн байгуулал гэх мэтийг иж бүрэн хөгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан боловч хүчин чадал нь алсдаа хангалтгүй болж, эдийн засаг, худалдаа импорт, экспортын хэмжээ хурдацтай өсөн нэмэгдэхэд саад болж, хүчин чадлыг өргөжүүлэх, шинэчлэн байгуулах хэрэг зайлшгүй гарч ирсэн юм. Дээрхи хүчин чадлын өргөтгөл, шинэчлэн байгуулах ажилд Хятад, Монголыг холбодог төмөр замын шугамыг шинээр байгуулж, ачааны вагоны дугуй тэвшийг солих, солих төхөөрөмжийн үйлдвэрлэлийн шугамыг өөрчлөх, рельсийн замыг өргөжүүлэн байгуулах, олон улсын стандартын дугуйны зохион байгуулалтын талбай зэрэг багтана.

Эрлян хотын галт тэрэгний буудал, талбайг өөрчилсний дараа Эрляний хилийн боомтын буудлын бараа тээвэрлэх хүчин чадал нэмэгдэж, урьд өмнө цуваа нэг бүрийг чигжин бүрэн дүүргэхэд 35 минутын хурд зарцуулж байсан бол одоо 10 минутанд хийх болов. Үүний зэрэгцээ дугуй тэвшийг шинээр сольж, тоог нэмэгдүүлэн, дугуй солих үйлдвэрлэлийн ажиллагаа урьд нь нэг удаад дөнгөж 24 байсан бол өөрчилж, одоогийн байдлаар нэг удаад 48 болж, улмаар дугуй солих хурд 1 дахин өслөө. Шууд тээвэрлэлт, ачаа солих хүчин чадал одоогийн 500 wang- аас 1000 wang тн хүртлээ нэмэгдсэн байна.

Эдийн засгийн бүтээн байгуулалтын хурдыг аажмаар нэмэгдүүлэхийн тулд Монгол Улсын засгийн газраас дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж, Монгол Улсын УИХ-аас 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр гаргасан “Мянганы зам”-ын тухай тогтоолын 9 дүгээр зүйлд засвар оруулан баталж улмаар 2002 оны эхээр Монгол, Хятадын хилийн боомт Замын-Үүдийг Чөлөөт худалдааны бүс болгож бүтээн байгуулалт хийхээр шийдвэр гаргасан нь хууль эрхийг баталгаажуулж өгсөн юм. Хэдийгээр янз бүрийн хүчин зүйлийн нөлөөнөөс болж (гол нь эдийн засгийн шалтгаан) дээрхи хууль, дүрэм журам бүрэн дүүрэн хэрэгжиж чадахгүй байгаа боловч үндсэндээ Монгол Улсын шинээр байгуулагдсан засгийн газар улсынхаа дотоод улс төрийн байдлаа зайлшгүй тогтвортой, баталгаатай болгож, олон улсын тусламжийг үр ашигтай зарцуулах, байгалийн нөөц баялгаа үр өгөөжтэй нээн хөгжүүлэх, мөнгө санхүүгийн хуримтлалыг аажмаар нэмэгдүүлэх, удирдлагын менежментийн төвшинөө түргэн дээшлүүснээр Монгол Улсынхаа эдийн засгийн хүндрэлийг даван туулж, өнөөгийн төлөвлөсөн зорилгодоо хүрч чадна гэдэгт итгэл дүүрэн байна.

Нөгөөтэйгүүр дан ганц цэвэр бараа бүтээгдэхүүний импорт, экспорт нь худалдааны нийт хэмжээг өөрчлөхөд маш хэцүү, учир нь худалдааны асар том хэмжээг бүрдүүлэхэд зөвхөн хоёр талын харилцан хөрөнгө оруулалтанд тулгуурладаг. Өвөр Монгол болон Монгол Улс бүр эртнээс

худалдаа наймаа эрхэлж голдуу малын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, модон эдлэлийн бүтээгдэхүүн, хувцас хунар, хагас боловсруулах бүтээгдэхүүн хийж иржээ. Үүнд гол төлөв жижиг, дунд болон хувийн үйлдвэр аж ахуйн газар зонхилж байснаас эдийн засгийн бодит хүч сул дорой, хөгжил удаашралтай хангалтгүй байна. Энэ нь Хятад Монголын харилцааны өнөөгийн байдалд, хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааны далд нөөц боломжийг бүрэн илрүүлээгүй байгаатай холбоотой. ӨМӨЗО-ы дарга Янь Жин Монгол Улсад айлчлах үеэр хийсэн хоёр талын уулзалт дээр хэлсэн үгэндээ БНХАУ-ын ӨМӨЗО болон Монгол Улс нь хил залгаа, эдийн засаг, соёлын зэрэг салбарт харилцан бие биеэ нөхөх, харилцан адил төстэй шинжүүд байгаа нь хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны чухал тавцан юм гээд, Ху Жиньтао дарга Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр гаргасан хоёр улсын хамтарсан мэдэгдлийн үзэл санааг аажмаар хэрэгжүүлж, хоёр тал найрсагаар харилцан туслах, шинжлэх ухаан, техник, соёл, эрүүл мэнд, боловсролын солилцооны үндсэн дээр алхам алхамаар эдийн засаг, худалдааны салбарын иж бүрэн хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар санал солилцсон юм. Түүнээс хойш өнөөдөр хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа улам бүр гүнзгийрч, шат дараалан хөгжих үндэс суурь тавигдлаа гэж онцлон тэмдэглэсэн юм.

Өвөр Монгол болон Монгол Улсын хоорондын худалдаанд хөрөнгө оруулалтыг татах аргыг өөрчилж, тогтмол нэмэгдүүлэхийн тулд, өнөөдөр Өвөр Монголын харьцангуй том 15 үйлдвэр аж ахуйн газар Монгол Улсад хамтран хөрөнгө оруулах, хамтран ажиллах, хувьцаа эзэмшихэд оролцох гэх мэт хэлбэрээр хөрөнгө оруулаад байна. Хятадын талын хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 1,8 тэрбум ам.долларт хүрч, хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд мөн барилга-инженерийн ажлыг хариуцан эрхлэх, хүнсний нарийн ногоо тарих гэх мэт энгийн хөдөлмөрт хамтран ажиллах, цахилгаан эрчим хүч, орд газрыг нээн олборлох, тариаланжуулах, (ургамал ногоо тарих), нэхэх, сүлжих, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах зэрэгт хүртэл хөгжүүлэн хүрээгээ өргөжүүлэх хэлбэрээр олон шатны хамтын ажиллагаа өрнүүлж байна. Өвөр Монгол болон Монгол Улсын хоорондын гадаад худалдааны гол дүн харьцангуй доогуур байгаа хэдий ч хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа аажмаар хөгжиж, Өвөр Монгол болон Монгол Улсын худалдаа өдрөөс өдөрт сайжирч, Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, хоёр орны ард түмний уламжлалт найрсаг харилцаан дахь зуучлалыг хариуцан авч, хүчин чармайлт гарган Өвөр Монголын Өөртөө Засах Орон гүүрийн үүрэг гүйцэтгэх нь зайлшгүй.

Хятад хэлнээс орчуулсан Ч.Батцэцэг (ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор /Ph.D/)